

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Лувсангийн Лхагва	Дугаар	L121
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Эрдэнэцагаан
Төрсөн газар	Эрдэнэцагаан	Төрсөн он	1944
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хавхчин хурал	Сүм хийдийн дугаар	СБЭЦ 003
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 26	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Хавхчин хурал

-Хавхчин хурал гэдэг нь их эртний хурал гэсэн үү?

Эртний хурал гэсэн. Егүзэр ламхайн хийдээс өмнөх хурал юм гэсэн. Егүзэрийн сүм чинь одоо нэг 230 хэдэн жилийн өмнөх гэсэн.

-Энэ Хавхчин хурал гэдэг?

Тэрнээс өмнө байсан гэсэн.

-Яагаад Хавхчин хурал гэж нэрлэсэн юм бол?

Хатгин омгийн нүүдэлчин дотор Хавхчин отог гэж цөөхөн улс байсан тэд нарын сүм юм гэсэн. Тэгээд Хавхчин хурал гэж нэрлэсэн гэж дуулсан.

-Тэгээд ямар учиртай хурал байсан юм бол?

Учрыг нь мэдэхгүй. 8 ламтай байсан юм гэнэ лээ гэж би дуулсан. 3 өрөө байшинтай, 3 гэрийн бүүртай ийм л газар байсан.

Энэ жил энийг мотоциклтой хүмүүс үхчих шиг болсон. Аваад базаасан юм ч байгаагүй байх. Энэ хавьд л үхчих шиг болсон.

-Энд ямар лам нар сууж байсан юм бол оо? Тэргүүн нь хэн гэдэг хүн байсан юм бол?

Мэдэхгүй ээ.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Хэдэн оны үед байгуулагдсан юм бол?

Энэ одоо барагцаагаар 250-аад жилийн тэртээд л байсан сүм гэж ярьдаг юм. Егүзэр ламхайн хийдийг байгуулахаас өмнө энд байж байсан сүм. Энэ бол эртний сүм ээ л гэж ярьдаг байсан юм.

-Хэзээ баларч үгүй болсон юм? Хэдэн он хүртэл хурж байсан юм бол?

Энэ бараг 19 37 оны үе хүртэл хурсан байх. Тэгээд л юмгүй болсон байх. Энэ одоо харагдах юм байхгүй.

Энэ манай хатгиныхны дотор байдаг хэдэн омог улс л даа. Эрдэнэцагаанд Хавхчин овогтой хүмүүс нэлээн бий. Тэгэхлээр эд чинь бол ийм юм. Чингисийн дараа Онон мөрний хөвөөнөөс Добучи мэргэний 3 хөвгүүнд Хатгиний 3 хошууг хувааж өгөхгүй юу. Дээд Хатгинууд гэж энд хуваагдсан. Дээд Хатгинд байгаа хавхчин гэж уул нь 16-хан өрх юм гэсэн. Баруун хар хавхчин гэдэг юм. 10-хан өрх юм гэсэн. Одоо бол гадаадад ч бий дотоодод ч бий. Одоо уугуул нутагтаа байгаа энэ голын нэлээд айл өрхүүд дээд хавхчингууд байна. Ер нь энэ хавьд 120 өрх айл бий. Энэний 40-50 нь хавхчингууд байгаа байх.Надаас эхлээд Хатгины хавхчин байна.